



**“АР СИ ЭС СИ” ХХК**

УЛААНБААТАР ХОТ-16081, БАЯНГОЛ ДҮҮРЭГ, 5-Р  
ХОРОО, 10-Р ХОРООЛОЛ,  
КРИСТАЛЛ СИТИ-102, №501 ТООТ

**ЗУРГИЙН ШИФР 10/18**

**УЛААНБААТАР-АРВАЙХЭЭРИЙН А0301 ЗАМЫН  
Км353+000-Км411+160-ЫН ХООРОНДОХ  
ХЭСГИЙН ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН  
НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСЛИЙН ТАЙЛБАР  
БИЧИГ**

**БОТЬ-5**

Улаанбаатар хот 2018 он



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР  
ЗАМ, ТЭЭВРИЙН  
ХӨГЖЛИЙН ЯАМ

Захиалагч:  
Зам Тээвэр Хөгжлийн Яам



Зөвлөх:  
“АрСиЭсСи”ХХК

**УЛААНБААТАР-АРВАЙХЭЭРИЙН А0301 ЗАМЫН  
Км353+000-Км411+160-ЫН ХООРОНДОХ ХЭСГИЙН  
ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ  
ТӨСЛИЙН ТАЙЛБАР БИЧИГ**

**БОТЬ-5**

ЗАХИРАЛ: ...../Д.НЯМДАВАА/

ИНЖЕНЕР: ...../Д.БАТБОЛД/

Улаанбаатар 2018 он

БАТЛАВ.  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

УЛААНБААТАР-АРВАЙХЭЭР ЧИГЛЭЛИЙН 371-431 КМ-ИЙН ХООРОНД 60 КМ  
АВТО ЗАМЫН ИХ ЗАСВАР, ШИНЭЧЛЭЛТИЙН АЖЛЫН НАРИЙВЧИЛСАН  
ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2018 оны 05 сарын 09-ний өдөр

30/18

Улаанбаатар хот

- |                                       |   |
|---------------------------------------|---|
| 1. Зураг төсөл боловсруулах үндэслэл  | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 38 дугаар тушаалаар батлагдсан “Улсын чанартай авто зам, гүүрийн засвар арчлалтын 2018 оны төлөвлөгөө”-нд заасны дагуу   |
| 2. Байршил                            | Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн 371-431 км-ийн хооронд  |
| 3. Замын хучлага                      | Тооцоогоор  |
| 4. Хучилтын бүтээц                    | Тооцоогоор  |
| 5. Төлөвлөлтийн норм                  | <ul style="list-style-type: none"><li>• “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016</li><li>• “Авто замын гүүр ба хоолой төсөллөх” БНБД 32-02-12;</li><li>• “Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл” АЗУАГН 2.01.01-2004</li><li>• “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх” БНБД 22.01.01*/2006</li><li>• Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл” АЗУАГН 2.01.01-2004</li><li>• “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх” БНБД 22.01.01*/2006</li><li>• “Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл” БНБД 11-07-04-ын II хэсэг инженер геодезийн ажил. “Геодезийн ажил” БНБД 3.01.03-88</li></ul> |
| 6. Зураг төсөл зохиох үе шат, хугацаа | Нарийвчилсан зураг төслийг 2018 оны 9 дүгээр сард багтаан гүйцэтгэнэ.   |
| 7. Зураг төслийн иж бүрдэл            | <ul style="list-style-type: none"><li>➤ Замын нийт уртад техник ашиглалтын түвшингийн судалгаа, далан, сууринд ашигласан материалын судалгааны дүн, замын эвдрэлийн шалтгааныг тогтоосон дүгнэлт;</li><li>➤ Тайлбар бичиг</li><li>➤ Техникийн шаардлага</li><li>➤ Ажил гүйцэтгэх аргачлал</li><li>➤ Геодезийн хэмжилтийн тайлан</li></ul>   |

- Хучилтын тооцоо
- Ус зайлуулах байгууламжийн тооцоо
- Хөдөлгөөний аюулгүй байдлын дүгнэлт
- Ажлын нэр төрөл, тоо хэмжээ /ЗТАЖЯ-ны сайдын 2007 оны 187 тоот тушаалаар батлагдсан төсвийн нормын дагуу/
- Их засвар, шинэчлэлтийн ажлын төсөв
- Замын их засвар, шинэчлэлтийн ажилтай холбоотой шороон орд, материал ашиглах газар олгосон орон нутгийн засаг захиргааны захирамж болон бусад зөвшөөрөл
- Зураг төслийн иж бүрдэл тус бүрийг баталгаажуулсан магадлалын ерөнхий дүгнэлт

#### 8. Зураг төслийн байгууллага

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” Монгол улсын хуулийн дагуу сонгон шалгаруулна.

#### 9. Захиалагч байгууллага

Зам, тээврийн хөгжлийн яам

#### 10. Онцгой нөхцөл

- Замын шинэчлэх хэсгийн техник ашиглалтын судалгааны дагуу асфальтбетон замын далан ба суурийн үеийн даац (CBR)-ыг тодорхойлж, шаардлага хангаагүй тохиолдолд далангийн дээд үе ба суурийг солихоор зураг төсөлд тусгах;
- Захиалагч байгуулагатай засварын төрөл, хучилтын хийцийг танилцуулж, зөвшилцөх;
- Ус зайлуулах байгууламжид судалгаа хийж шаардлагатай хийц, засварыг нэмж төлөвлөх;
- Их засвар хийгдэж байгаа замд орон нутгийн замын цагдаагийн газраас гаргасан авто тээврийн хэрэгслийн ослын судалгааны дагуу үзэгдэх орчин хязгаарлагдсан хэсэгт замын далан, хучилтыг өргөсгөх, эргэлтийн радиусыг нэмэгдүүлэх тооцоог хийж, зураг төсөлд тусгах;
- Хучлагын зузааныг тооцоогоор, хуучин хучилтыг газар дээр нь дахин боловсруулах аргаар эргүүлэн ашиглах боломжийг судалж, зураг төсөлд тусгах;
- Одоо байгаа замын даланг ашиглах, ухмалыг шаардлагатай хэмжээнд хүртэл өргөсгөх, тээврийн хэрэгсэл түр зогсох, зорчигч саатах зогсоол байгуулах, шаардлага хангасан материалыг ашиглахаар зураг төсөлд тусгах;
- Хучилтын бүтээцийг ЗТБХБСайдын 2010 оны 313 дугаар тушаалаар батлагдсан

“Монгол орны асфальтбетон хучлагатай авто замын хучилтын хийцийн жишиг цомог”-ийг жишиг болгох;

- Уулзвар, орц гарцын зургийг дахин нягталж, шаардлагатай тохиолдолд дахин шинэчлэн зураг төсөлд тусгах;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан хийц, тэмдэг тэмдэглэгээ, тоноглолыг оновчтой төлөвлөх;
- Шинэчилсэн зураг төсөлд Магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулах;
- Замын барилгын ажлын явцад тээврийн хөдөлгөөнийг саадгүй явуулах түр замын ажлын хэмжээг гаргаж, зураг төсөвт тусгах;


Хянасан:

Зам тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Зам тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Замын ашиглалт, засварын хэлтсийн дарга


Боловсруулсан:

Зам тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн



Д.ДОРЖХАНД

Х.ОРГИЛ-ЭРДЭНЭ



Д.ЭНХТУЯА

2018.05.09.

## **БҮЛЭГ-1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Монгол улсын холбогдох хууль, тогтоомжинд үндэслэн зураг төслөх зөвлөх үйлчилгээний “Ар Си Эс Си” ХХК нь Монгол улсын Зам, Тээврийн Хөгжлийн Яамтай 2018 оны 07 сарын 31-ны өдөр № 155 тоот “Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн 371-431км-ийн хооронд 60км авто замын их засвар, шинэчлэлтийн ажлын нарийвчилсан зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан. Зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг Зам, Тээврийн Хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн дарга 2018 оны 05 сарын 09 өдөр дугаар № 30/18 баталсан болно.

Зураг төсөл боловсруулах даалгаварт одоо байгаа Км-ийн тэмдгийн заалтаар (371км-431км) байршлыг тусгасан бөгөөд ажлын зураг тусалд өгөгдсөн хэсэгт ЗТЯ-ны сайдын .....тушаалаар батлагдсан Улаанбаатар-Арвайхээр А0301 чиглэлийн авто замын паспорт-д заасан эхлэл цэг, урт, км-ын заалтыг баримтласан болно. Тус чиглэлийн авто замыг газар дээр нь нөхцөл байдалтай танилцаж эвдрэлийн судалгаа, техник ашиглалтын судалгааны хийсэний үндсэн дээр замын их засварын зураг төслийг Км353+600 (одоо байгаа км-ийн шонгийн заалтаар 372км) эхлүүлэн төгсгөл цэг хүртэл Км411+160 хооронд 57.56км хэсэгт зураг төслийг боловсруулсан болно.

### **1.1. ҮНДЭСЛЭЛ**

- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 38 дугаар тушаалаар батлагдсан “Улсын чанартай авто зам, гүүрийн засвар арчлалтын 2018 оны төлөвлөгөө”-нд заасны дагуу
- "Автозам төсөллөх" ЗЗБНБД 22-004-2016
- "Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын жишиг үнэ" БД81-104-02,
- Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын техникийн шаардлага
- "Авто замын гүүр ба хоолой БНБД 32-02-12,
- Авто замын тэмдэг.Техникийн ерөнхий шаардлага. MNS 4957:2014,
- Авто замын тэмдэглэл.Техникийн ерөнхий шаардлага. MNS 4759:2014 болон бусад холбогдох норм дүрмүүдийг үндэслэх.
- “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга байгууламж төлөвлөх”БНБД 22.01.01.2006
- “Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл” АЗУАГН 2.01.01-2004
- “Монгол орны асфальтбетон хучлагатай автозамын хучилтын хийцийн цомог”

### **1.2. АЖЛЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН**

- БОТЬ-1. АВТО ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ
- БОТЬ-2. ХӨНДЛӨН ОГТЛОЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ (Км353+600- Км 383+180)
- БОТЬ-3. ХӨНДЛӨН ОГТЛОЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ (Км383+200- Км 411+160)

- БОТЬ-4. ТЕХНИК АШИГЛАЛТЫН ТҮВШИНГИЙН СУДАЛГАА
- БОТЬ-5. ТЕХНИКИЙН ШААРДЛАГА
- БОТЬ-6. ТАЙЛБАР БИЧИГ
- БОТЬ-7. ИНЖЕНЕР ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН
- БОТЬ-8. БАЙРЗҮЙН ЗУРАГЛАЛЫН ТАЙЛАН

### 1.3. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Төслийн нэр:** УЛААНБААТАР-АРВАЙХЭЭРИЙН А0301 ЗАМЫН Км353+600-Км411+160-ЫН ХООРОНДОХ ХЭСГИЙН ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ

**Байршил:** Өвөрхангай аймгийн Өлзийт сум, Зүүнбаян-Улаан сум, Тарагт сум

### 1.4. ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГА:


- “Монгео-Экотех” ХХК Инженер-геологийн судалгаа хийж тайлан
- “RDAC” ХХК Замын эвдрэлийн судалгаа, техник ашиглалтын судалгаа

### 1.5. ТӨСЛИЙН ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

Хүснэгт -1

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Засварын зураг төсөл
1	Замын зэрэг	-	Төв зам 1Г-ГЗ-ЗХГ-2-80
2	Замын урт	км	57,56
3	Тойруугийн тоо	ш	200
4	Тойруугийн хамгийн бага радиус	м	340
5	Тойруугийн хамгийн их радиус	м	30000
6	Тойруугийн нийт урт	м	20910
7	Тойруугийн трассад эзлэх хувь	%	36,0
8	Дагуугийн хамгийн их налуу	%	6,2
9	Дагуугийн хамгийн их налууугийн үргэлжлэх урт	м	260
10	Замын далангийн өргөн	м	11,8
12	Зорчих хэсгийн өргөн	м	7,0
13	Хөвөөний өргөн	м	2,4x2
14	Далангийн хажуу налуу	m:n	1:1,5 1:2,5
15	Зогсох үеийн үзэгдэх зай	м	130
16	Гүйцэж түрүүлэх үзэгдэх зай	м	245
	Хучлагын төрөл	-	Асфальт бетон

## 1.6. ТӨСЛИЙН БАЙРШИЛ



Зураг-1: Байршлын тойм зураг

## **БҮЛЭГ-2. ИХ ЗАСВАР ХИЙГДЭХ ЗАМЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

### **2.1. ТРАССЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн А0301 кодтой авто зам нь 2 урсгал, 2 эгнээтэй, 7м өргөн зорчих хэсэг, 1.5-2.5м өргөн хөвөө, нийт далангийн өргөн 10-12м өргөнтэй хөнгөвчилсөн асфальтбетон хучлагатай.

Уг зам нь төсөллөлтийн нормоор замын ангилалын хувьд төв зам ба зэрэглэлийн хувьд 1Г бөгөөд Үйлчилгээний түвшин нь C,D болно. Зориулалтын хувьд аймгийн болон бүс нутаг хоорондын зорчих хөдөлгөөний хэрэгцээг хангах зориулалттай манай орны баруун аймгуудруу зорчдог гол зам болно.

Нийт замын геометр хэмжээг 1Г замын төсөллөлтийн зарчим шалгуур үзүүлэлтийн шаардлагыг баримтлан төлөвлөсөн ба засварын ажлыг хучилтын хийцийг хүчитгэх, өнгөлөх, давуулах далан барих, өндөрлөх зэргээр төлөвлөв.

Тус чиглэлийн зам нь1970-аад оны үед барьж улмаар 2001-2003 онд хэсэгчилсэн их, дунд, урсгал засвар шинэчлэлийг Дэлхийн банкны зээлийн хөрөнгөөр засварласан бөгөөд түүнээс хойш их засвар хийгдээгүй эдэлгээний хугацаа болон насжилтын хувьд их засвар хийгдэх хугацаа нь болсон байна. Ашиглалтын хугацаанд их болон дунд засварын ажил хийгдээгүй жил бүр хэсэгчлэн нөхөөс хийх байдлаар засч байсан ба 2016 онд 4 км, 2017 онд 1.8 км, 2018 онд 4.2 км авто замд хучилтад засвар хийсэн ч баруун аймгуудыг зорьсон авто машины хөдөлгөөн тасрахгүйн зэрэгцээ уул уурхайн хүнд механизмууд байнга холхидгоос зам байнга эвдэрсээр байна. Ашиглалтын хугацаанд засварын ажлыг ихэвчлэн дараах байдлаар гүйцэтгэж байсан байна. Үүнд:

- 1) Далан, суурь, хучилтыг сольсон,
- 2) Хуучин хучилт дээр асфальтбетон өнгөлгөө хийсэн,
- 3) Хөнгөвчилсэн хучилттай хэсэгт гадаргуун боловсруулалт хийсэн,
- 4) Зөвхөн хучилт сольсон гэх мэт.

Зураг төслийн даалгавраар өгөгдсөн их засвар хийгдэх авто замын эхлэл нь тус чиглэлийн замын 372км шон (ажлын зургийн Км353+600) буюу Өлзийт сумын 1-р багийн нутагт Сангийн далайн талд Хужирт сумруу салдаг гарц орчмоос эхлэн Арвайхээр сум хүртэл 57,56км үргэлжлэнэ. Энэхүү замын ихэнх нь хэсэг нь зөвхөн өнгө боловсруулалт хийгдсэн. Замын анхны хучилт нь зам дээр холих аргаар хийгдсэн хөнгөвчилсэн хучилттай зам юм.

Улаанбаатар - Арвайхээр чиглэлийн хатуу хучилттай замын Км353+600-Км411+160км хэсэгт их засвар хийх ажлын инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулахаар 2018 оны 7, 8, 9-р сард хийсэн талбайн дээр хийсэн эвдрэлийн судалгаа, техник ашиглалтын түвшин тогтоох судалгаа болон инженер геологийн

дүгнэлт, бусад судалгааг үндэслэн засварын ажил гүйцэтгэх аргачлал төрлүүдийг сонгосон болно.

## 2.2. ТЕХНИК АШИГЛАЛТЫН СУДАЛГАА

Авто зам, замын байгууламжийн техник ашиглалтын байдалд тавигдах үндсэн шаардлага, ашиглалтын байдлыг үнэлэх, засвар арчлалтын ажлыг төлөвлөх зарчмыг тодорхойлох нь авто замын чанар байдалд үнэлэлт өгөх, өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

Авто замын салбарт “Авто зам, замын байгууламжийн техник ашиглалтын түвшинг тогтоох, үнэлэх аргачлал” MNS 6441 : 2014 гэсэн стандарт мөрдөгдөж байна. Энэ стандартаар ТАТ-г хэрхэн тогтоох, түвшинг хэрхэн үнэлэхийг аргачлан заасан байна. ТАТ-ийн үнэлгээг ашиглалтын 19 үзүүлэлтээр хийж энэ түвшинг үндэслэн доорхи хүснэгтэд заасан байдлаар засвар, арчлалтын ажлыг тодорхойлохоор аргачилжээ.

### Хүснэгт-2. Автозамын ТАТ-ийн нэгдсэн үнэлгээний үзүүлэлт

№	Авто замын техник-ашиглалтын түвшин, ТАТ	Үнэлгээ	Засвар арчлалтын ажлын төрөл
1	100 - 86	Маш сайн	Арчлалтын ажил, улирлын урсгал засвар
2	85 – 75	Сайн	Ээлжит засвар (дан гадаргуун боловсруулалт, битумэн цацлага гэх мэт)
3	74 – 60	Хангалттай	Ээлжит засвар (давхар гадаргуун боловсруулалт, асфальтан хольц дэвсэх гэх мэт)
4	59 – 41	Хангалтгүй, муу	Их засвар
5	40 - 0	Маш муу	Их засвар эсвэл шинэчлэлт

Энэ хүснэгтээс харахад засвар, арчлалтын төрлийг тоймлон харж болохоор байгаа бөгөөд ТАТ тогтоосон үзүүлэлт ч цөөхөн байгаа юм.

Авто замын түвшин тогтоох ажлыг 2014 онд батлагдсан “Авто замын техник ашиглалтын түвшин тогтоох, үнэлэх аргачлал” стандартын дагуу доорх үзүүлэлтүүдийн хэмжилтийг газар дээр нь гүйцэтгэлээ. Үүнд:

1. Автозамын урт
2. Авто замын геометр хэмжээс
3. Замын зорчих хэсгийн хөндлөн хэвгий
4. Далан, суурийн ачаа даацын харьцаа
5. Замын хучилтын хотойлт
9. Хучилтын дугуйн мөрний ховил
10. Хучилтын зузаан, нягт
11. Асфальтбетоны ширхэглэл
12. Ус зайлуулах байгууламжийн үзлэг
13. Замын хашилтын бат бэх,

- |   |                       |
|---|-----------------------|
| 6. Замын гадаргуун тэгш байдал          | эвдрэлийн үзлэг       |
| 7. Хучилтын барзгаржилт                 | 14. Замын тэмдэглэгээ |
| 8. Хучилтын гулсалтын эсэргүүцэх чадвар | 15. Тоноглолын үзлэг  |

ТАТ-ийн тайланд дээрх үзүүлэлтүүд болон зөвлөхийн зүгээс нийт 42 үзүүлэлтээр ТАТ-ийн үнэлгээ хийж, товчоо хүснэгтэд тухайн авто замын чанар байдлыг өнгөний тусгалаар харуулж, чухам ямар засвар хийхийг 500м тутамд тодорхойлсон. (ТАТ-ийн тайлан үзэх) Нэгдсэн үзүүлэлт бүхий хүснэгтээс замын ямар хэсгүүдийг нэгтгэн аль төрлийн засвар хийх боломжтойг тодорхойлж болно. Олон улсад, Авто замд хийх засварын ажлыг, энэ чиглэлээр олон жил ажилласан туршлагатай инженерүүд тодорхойлж, түүнийгээ техникийн, ашиглалтын түвшингийн үнэлгээгээр нотолдог тогтолцоотой байдаг. Зөвлөхүүд засварын ажлын төрлийг сонгохдоо энэ зарчмыг баримталсан болно.

Их засвар хийгдэх Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн 57.56 км замын ТАТ-ийн техникийн нэгдсэн үнэлгээг, ашиглалтын байдлыг оноо, дүн тавьж 500м тутам үнэлэн гаргасан техник ашиглалтын түвшинг үнэлж, үнэлгээг ашиглаад ТАТ-ийн үзүүлэлт бүрт тохируулсан 1-9 оноо үнэлгээ өгсөн. Үзүүлэлтүүд болон газар дээр нь хийсэн судалгааны тайлангийн өгөгдлийг үндэслэн, Зөвлөхүүд энэ замын ашиглалтын түвшинг 95%-д хүргэх зорилгоор засварын дараах төрлүүдийг сонгон гүйцэтгэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд: **Ерөнхий дүгнэлт- Энэхүү 57.56 км асфальтбетон хучилттай замын техник, ашиглалтын дундач түвшин нь 26.1% байгаа тул нэн яаралтай засварлах шаардлагатай. Иймд:**

1. Тухайн замд мэргэжлийн инженерүүд, Зөвлөхүүдийн хийсэн үзлэг, судалгаа, хэмжилт, тооцоо тэндээс гарсан дүгнэлтүүд, Авто замын ашиглалтын техникийн үзүүлэлтийн үнэлгээ, энэ хэсгийн дундач техник ашиглалтын түвшин 24.8%-тай буюу маш муу үнэлгээтэй байгааг үндэслэн 354-р км-с 396-р км-ын хоорондох замыг иж бүрэн сэргээн засварлаж шинэчлэх шаардлагатай гэж үзэж байна. Энэ замыг бүрэн шинэчлэх өөр нэг шалтгаан бол замын хучилтын хийц гээд байхаар зүйл бараг байхгүй, замын доорхи хоолойнууд их хэмжээгээр эвдэрсэн, замын хучлага маш их нөхөөстэй, нүхтэйд байгаатай холбоотой юм.
2. 2001 онд хийгдсэн шинэчлэлд хамрагдсан учраас 396.0-398.5км хоорондох, 407.0км-411.5 км хоорондох замын хэсгүүд харьцангуй гайгүй үзүүлэлттэй байна. Гэхдээ замын техник ашиглалтын дундач түвшин 31.8%-30.6% байгаа учраас зайлшгүй их засвар хийх шаардлагатай.

3. 398.5-402.5 км хоорондох мөн 404-407-р км хоорондын замын хэсгүүдийн дундач ТАТ-24.8%-28,9% байна. Энэ хэсэгт замын хиймэл байгууламжийн төлөвлөлт буруу хийснээс, мөн замын далан нам төлөвлөгдснөөс шалтгаалан бага зэргийн үер болоход зам сэтэрч, өвөл цас хунгарлаж хөдөлгөөн саатуулан зам ашиглагч байгууллагад байнга хүндрэл учруулдаг учраас зайлшгүй шинээр төлөвлөлт хийж, шинэчлэх шаардлагатай.
4. 402.5-404.0км хоорондох замын хэсгийн дундач ТАТ-29.5% байна, замын энэ хэсгээр бэлийн ус буудаг учраас нилээд өвөрмөц төлөвлөлт шаардлагатай.

### **2.3. ЗАМЫН ЭВДРЭЛИЙН СУДАЛГАА**

Улаанбаатар - Арвайхээр <А0301> чиглэлийн автозамын 372-р км-ийн тэмдэгтээс их засвар хийх зам эхлэх бөгөөд энэхүү замын КМ353+600-КМ354+520 хооронд нь 920м хучилтгүй болсон ба бусад хэсэгт нь асфальтбетон хучилттай авто замтай болно. Засвар хийгдэх хэсэгт нийт 2 байршилд төмөрбетон гүүр (Онгийн гол дээр том гүүр 162у/м, нэг жижиг гүүртэй 28у/м ) 59 байршилд дугуй, дөрвөлжин янз бүрийн хэмжээтэй чулуун болон төмөрбетон хоолойнуудтай болно.

Зураг төслийн зөвлөхийн баг газар дээр нь ажиллаж, тухайн замын хийцүүдэд одоогийн байдлаар үүсээд байгаа эвдрэлийг судалж, төрөл тус бүр дээр нь хэмжилт хийж, хучлага, хоолой, тоноглол гэсэн үндсэн 3 ажил дээр ажлын тоо хэмжээг, нарийвчилсан зураг төслийг боловсруулан гаргаж, уг эвдрэлийн судалгааг гаргасан болно.

Их засвар хийгдэх замын далангийн материалын хувьд ерөнхийдөө боломжийн сайн баригдсан бөгөөд нь энэ жилийн борооны үерээр хэд хэдэн байршилд сэтэрсэн, давж урссанаас өөр овойлт, суулт, хөндлөн хагарал, нарийсалт ноцтой эвдрэл гараагүй, геометрийн үзүүлэлтүүд хэлбэр дүрс нь алдагдсан боловч ашиглалтын ерөнхий байдал нь хэвийн байна.

ТАТ-ийн хэмжилтийн үр дүнгээс үзэхэд замын далан, суурийн ачаа даацын харьцааг DCP багажаар нийт 30 цэгт дээр хэмжсэн үр дүнгээс үзэхэд дээд хэсгийн (DCP хэмжилтийг зорчих хэсгийн ирмэг хөвөөн дээр хийсэн) 15-20см үе нь хөвөөний материал байсан ба түүнээс доорх далангийн 40см хүртэлх үеийн CBR-ийг тодорхойлсон байна.

Суурь, далангийн дээд үе гэж үзэн үр дүнг нэгтгэн дүгнэхэд суурь үеийн 70% нь CBR>30%- тай байна. Далангийн дээд үеийн хувьд 57% нь CBR<30%, 43% нь CBR>30%- тай байна.

Иймд зураг төсөл зохиогчоос одоо байгаа замын далан хучилтыг ашиглан, түүнийг бэхжүүлэх аргаар материалын чанарыг дээшлүүлж суурь болгон ашиглахаар төлөвлөсөн болно.

#### **2.4. ЗАМЫН ХУЧИЛТЫН СУДАЛГАА**

Замын эврэлийн судалгааг талбай дээр нь нүдэн баримжаа болон ТАТ тогтоосон судалгаанаас үзэхэд замын хучилтын эвдрэлээр нь трассыг дараах 2 хэсэгт хуваасан. Үүнд:

1. Км353+600 – Км395+760 их эвдрэлтэй
2. Км395+760 – Км411+160 бага эвдрэлтэй

Одоо ашиглагдаж буй замын эвдрэлийн шалтгаан нь цаг тухайд нь засвар хийж байгаагүй бөгөөд сүүлийн үед хүнд даацын тээврийн хэрэгсэл ихээр зорчих болсон, хөдөлгөөний эрчим ихэссэнтэй холбоотой хучилтын эвдрэлүүд их байна. Мөн замд ус зайлуулах хоолой, суваг шуудуу, уулын шуудуу зэрэг үер уснаас хамгаалсан байгууламж хангалтгүй, зам дээр хөндлөн болон дагуудаа ус зайлуулж чадахгүйгээс болж зорчих хэсэг дээр ус тогтон ул хөрс, сууриндаа нэвтэрч замын хучилт эвдэрсэн байна. Зарим хэсэгт их хэмжээний үер ус буусанаас болж намхан далантай хэсэгт далан сэтрэх, давж урсах зэрэг хур бороо, байгаль цаг уураас хамаарсан эвдрэлүүд их үүссэн байна.

Мөн зарим хэсэгт авто замын суурь үеийг барихдаа техникийн шаардлага хангахгүй материал ашигласанаас даланд пучин үүссэн овойлт суулт өгсөн байна.

Хучилтын их эвдрэлтэй Км353+600 – Км395+760 хооронд 42,16км хэсэгт хучилтыг өнгө боловсруулалтын аргаар хийгдсэн хэсэгт хамрагдаж байна. Энэ хэсгийн хучилт хэв гажилтын эвдрэлд орсон бөгөөд нөхөөс хийсээр байгаад засвар авахаа больсон, эвдрэл нь ихэвчлэн зорчих хэсгийн гадаргууд пучин үүссэж овойлт, суулт, ирмэгийн эвдрэл, нүхний эвдрэл гарсан, нүх маш их гарсан, хагарал ихтэй, зарим хэсэгчилсэн хийгдсэн нөхөөстэй бөгөөд авто замын хүйтэний хагарлыг цаг тухайд нь нөхөөгүйн улмаас хатуу хучилтад шугаман болон торон хагарал ан цав их бий болж улмаар бороо болон цас, мөсний хайлсан ус нэвчиж замын суурь бүтээцийн хэв гажилтад ихээхэн оруулж тэгш бусын үзүүлэлт шаардлага хангахгүй болгосон байна. Зам дээрх эвдрэлийн фото зургуудыг тайланд оруулж өглөө.

### ХУЧИЛТЫН БАЙДАЛЫН ЗУРГУУД



**Зураг-2. Км388+020 Асфальтобетоны зузааныг шалгаж байна. /захын хэсэг/**



**Зураг-3. Км362+540 Асфальтобетон хучилтанд үүссэн торон хагарал.**



**Зураг-4. Км357+320 Асфальтобетоны эвдрэлийн байдал**



**Зураг-5. Км389+860 Асфальтобетонд торон хагарал, нүх, дугуй мөрний ховил үүссэн байгаа нь**



**Зураг-6. Км356+240 Асфальтобетонд ирмэгийн эвдрэл, нүх, торон хагарал үүссэн байдал**



**Зураг-7. Км376+320 Асфальтобетоны нүхний эвдрэлийн хэмжээг гаргаж байгаа нь**



**Зураг-8. Км391+440 Их эвдрэлтэй хучилтын ерөнхий байдал -1**



**Зураг-9. Км355+100 Их эвдрэлтэй хучилтын ерөнхий байдал -2**




**Зураг-10. Км354+480 Асфальтобетон хучилтгүй болсон хэсэг**

Хучилтын бага эвдрэлтэй Км395+760 – Км411+160 хэсэгт суурь хучилтын байдал харьцангуй сайн, бага зэрэг дугуй мөрний ховил гарсан, хялгасан болон хөндлөн хагаралуудтай, тэгш байдал болон хучилтын геометр үзүүлэлтүүд зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа болно.



**Зураг-11. Км397+600 Бага эвдрэлтэй хучилтын ерөнхий байдал**

Гэвч уг хэсгийн Км398+040 – Км406+800 хэсэгт одоо байгаа замын далан хэт намхан байгаагаас хэд хэдэн байршилд ус давж урсан замыг эвдэн хөдөлгөөнийг хаадаг тул энэ хэсгүүдэд одоо байгаа замын даланг өндөрлөх, суваг шуудууг сэргээх, ус зайлуулах хоолой, давуулах далан зэргийг төлөвлөх шаардлагатай байна.






**Зураг-12: Үерийн ус давсан байдал /2018оны 8 сарын 7өдөр/**






**Зураг-13: КМ403+180 Ус давж урсдаг намхан далантай хэсэг**

Ажлын талбайн дээр хийсэн эвдрэлийн судалгаа, техник ашиглалтын түвшин тогтоох судалгаа, инженер геологийн дүгнэлт, бусад судалгааг үндэслэн хучилтыг дараах байдлаар засварлахаар төлөвлөв.

**Хүснэгт-3.Хучилт засварлах аргачлал**

Хучилтын төрөл		Хэмжээ (Урт, м)	Засварлах арга	Хөндлөн огтлолын төрөл
№	Байршил			
1	353+600 - 395+760	42160м	Далангийн материалыг асфальтын хамт 25 см Resucile-аар 4-6% цементтэй хольж суурь хийн, 8см хар дайрга, 3 см а/б хийх	 <p>Хучлагын асфальтобетон өнгө үе h=3см Хучлагын битумэн (харлуулсан) бугалсан чулуун суурь үе h=8см</p> <p>Одоо байгаа хуучин асфальтбетон хучилтыг хүйтэнээр дахин боловсруулж (Resucile) цементээр бэхжүүлсэн суурь (4-6% цемент) хийх h=25см</p>
2	395+760 - 398+040	2280	Эвдэрсэн хэсэгт нөхөөс хийх, тэгшилгээний үе 5 см а/б хийх	 <p>Хучлагын асфальтобетон өнгө үе h=5см Асфальтбетон тэгшилгээний үе h=1-5см</p>
3	398+040 - 402+260	4220	Далангийн материалыг асфальтын хамт 20см Resucile, Зургийн дагуу далан хийж өндөрлөх, 20см СТВ, 7см а/б хийх	 <p>Хучлагын асфальтобетон өнгө үе h=3см Хучлагын асфальтобетон суурь үе h=4см</p> <p>Цементээр бэхжүүлсэн суурь хийх h=20 см</p> <p>Одоо байгаа хуучин асфальтбетон хучилтыг хүйтэнээр дахин боловсруулж (Resucile) буцаан дэвсэх h=20см</p>

4	402+260	-	403+000	А/Б хучилт дээгүүр ус давж урсдаг хэсэг (Хуучин давуулах далангаар төлөвлөж хийсэн)	740	Давуулах далан хийх хэсэг. Хуучин а/б хучилт дээр 24 см бетон хийх	 <p>Цементбетон хучилт h=24см Хуучин асфальтбетон хучлага</p>
5	403+000	-	406+800	А/Б хучилт бага зэргийн нүхэн цоорол, хялгасан хагаралтай. Далан өндөрлөж, хоолой нэмэх хэсэг	3800	Далангийн материалыг асфальтын хамт 20см Resucle, Зургийн дагуу далан хийж өндөрлөх, 20см СТВ, 2үе 7см а/б хийх	 <p>Хучлагын асфальтбетон өнгө үе h=3см Хучлагын асфальтбетон суурь үе h=4см Цементээр бэхжүүлсэн суурь хийх h=20 см Одоо байгаа хуучин асфальтбетон хучилтыг хүйтэнээр дахин боловсруулж (Resucle) буцаан дэвсэх h=20см</p>
6	406+800	-	411+160	А/Б хучилт бага зэргийн нүхэн цоорол, хялгасан хагаралтай	4360	Эвдэрсэн хэсэгт нөхөөс хийх, 1 үе 5 см а/б хийх	 <p>Хучлагын асфальтбетон өнгө үе h=5см Асфальтбетон тэгшилгээний үе h=1-5см</p>

## **2.5. ЗАМЫН МАТЕРИАЛЫН СУДАЛГАА**

Улаанбаатар - Арвайхээр <A0301> чиглэлийн их засвар хийгдэх 57.56км автозамын их засварын барилга угсралтын ажилд уг замыг барьж байгуулах үед ашигласан хуучин шороон орд, карьер, ухмалын материалыг ашиглах зүйтэй байна.

Иймээс зөвлөхөөс талбай дээр хуучин шороон орд, карьеруудын судалгааг хийж дахин ашиглах нөөц боломжтой хэд хэдэн орд, одоо тус замын ашиглалт засварын ажлыг хариуцдаг АЗЗА ашиглаж буй шороон орд, хэд хэдэн ухмалаас дээж авч лабораторид шинжлүүлсэн болно.

Мөн хүснэгт-3 дурьдсан хучилтын засварлах аргачлал бүрд дурьдсан суурь болон хучилтын материалын судалгааг хийж зохих дээжүүдийг авч шинжлүүсэн. Тухайлбал одоо байгаа хучилтыг хүйтэнээр дахин боловсруулж цементээр бэхжүүлсэн суурь (ЦБС) төлөвлөгдсөн хэсэгт одоо байгаа хучилт, суурь, далангаас дээж авч ЦБС-ийн орц тогтоох шинжилгээ болон хуучин асфальтбетон хучилтын битумын хэмжээ ба материалын ширхэглэл тогтоох шинжилгээнүүдийг хийлгэсэн болно.

Одоо байгаа ухмалуудаас дээж авахдаа үзэгдэх орчин хязгаарласан цэгүүдээс дээж авсан болно. Хэд хэдэн байршилд эргэлт тойруутай хэсэгт ухмал, хагас ухмалууд нь тээврийн хэрэгсэл зорчиход үзэгдэх орчинд муугаар нөлөөлөхөөр байна.

Зураг төсөлд далан ба ухмалын хажуу налуу, хажуугийн шуудуу болон гадна налууг өргөтгөн шинэчлэх юм. Эдгээр хажуу налууг өргөтгөх, ухмалыг тэлэх ажлаас гарах материалыг зам засварын ажилд ашиглах зүйтэй байна.



**Зураг-14: Үзэгдэх орчин муу буюу тэлж ухах шаардлагатай ухмал. Ухмалын материалыг далан болон хөвөөнд ашиглах**

Далан, хөвөөний шинжилгээний дүн

Км364+440 орчимд байх ухмалаас авсан материалын шинжилгээний дүнгээс үзэхэд уг материал нь далан, хөвөөний шаардлага хангаж байгаа болно.

**Лабораторийн дүгнэлт:**



**ХЯНАЛТ СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ  
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**



Лаборатори № TL 89

**ДАЛАН СУУРИЙН МАТЕРИАЛЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**

Дугаар: он/№ 18/189  
Гүйцэтгэгч: "RCSC" ХХК  
Материалын зориулалт: Далан хөвөө  
Объектын нэр: Өвөрхангай аймаг А 0301 371-431 км 60км авто замын шинчлэл  
Дээж авсан байршил : Ухмалын материал  
Дээж авсан хүний нэр, албан тушаал : инженер Наранбаатар  
Шинжилгээнд ирүүлсэн дээжний Хүлээн авсан огноо Шинжилсэн огноо  
50 кг 2018.08.17 2018.09.03

Шинжилгээний аргын стандарт	Шинжилсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	Техникийн шаардлага	Үр дүн
MNS ASTM D2217:2014	53мм	%		100
MNS ASTM D2217:2014	37.5 мм	%		100.00
MNS ASTM D2217:2014	25мм	%		76.04
MNS ASTM D2217:2014	19 мм	%		60.69
MNS ASTM D2217:2014	9.5 мм	%		45.05
MNS ASTM D2217:2014	4.75 мм	%		33.50
MNS ASTM D2217:2014	2.36 мм	%		23.58
MNS ASTM D2217:2014	0.425 мм	%		9.66
MNS ASTM D2217:2014	0.075 мм	%		0.86
MNS ASTM D2217:2014	Хамгийн том ширхэглэл	мм		37.5
MNS ASTM D2217:2014	Ижил байдлын итгэлцүүр	%	5<	6.29
MNS ASTM D 4318:2006	Уян налархайн хязгаар	%		0.00
MNS ASTM D 4318:2006	Урсалтын хязгаар	%	<25	23.00
MNS ASTM D 4318:2006	Урсалт уян налархайн индекс		0-6	0.00
MNS ASTM D 1883:2002	Хөөлт	%	1>	0.05
MNS ASTM D 1883:2002	Хөрсний ачаа даацыг тодорхойлох	%	>30	27.0
MNS ASTM D 1557:2002	Хуурай үеийн хамгийн их нягт	г/см	1.70<	2.213
MNS ASTM D 1557:2002	Тохиромжтой чийгийн агуулалт	%		8.2

Лабораторийн эрхлэгч : ..... / Ч.Баттулга /  
Туршилт хийсэн инженер : ..... / А.Долгор /

Энэхүү шинжилгээний үр дүн нь зөвхөн лабораторид ирсэн тухайн дээжинд хамаарна.



Хучилтын бага эвдрэлтэй хэсэг болох Км395+760-Км398+040, Км406+800-Км411+160 (6640м) хооронд хучилтыг засварлах аргачлалд эвдрэлтэй хэсэгт нөхөөс хийж тэгш байдлыг хангах тулд тэгшилгээний асфальтбетон хийсэний дараа 5см асфальтбетон хучилтаар өнгөлөхөөр тусгасан. Энэхүү хэсэгт талбайд хэмжсэн судалгаагаар 691.5м<sup>2</sup> нөхөөс хийхээр тогтоосон. Одоо байгаа асфальтбетон хучилтаас дээж авч лабораторит шинжилгээ хийн битумын хувийг тодорхойлов.



**ХЯНАЛТ СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ  
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**



Лаборатори № TL 89

Асфальтбетон хольцыг угаасны дараах битумын хэмжээ ба ширхэглэл AASHTO T164

Байгууллагын нэр : RCSC ХХК

Дээж авсан он сар өдөр: 2018.09.03

Объектийн нэр: Өвөрхангай аймаг авто замын шинчлэл

Туршсан он сар өдөр: 2018.09.05

Байршил : АБЗ


код : 18/199-2

Туршилт				Материалын хувь		
①	Цаас + Дээж жин	г				1004.8
②	Цаасны жин	г				4.8
③	Дээжний жин	г		①-②		1000.0
④	Цаас+Эрдэс нунтагийн жин	г				14.9
⑤	Эрдэс нунтагийн жин	г		④-②		10.1
⑥	Нэрсний дараах дээжний жин	г				935.5
⑦	Дээж+Эрдэс нунтагийн жин	г		⑤+⑥		945.6
⑧	Битумын жин	г		③-⑦		54.4
⑨	Битумын хувь	%		⑧/③*100		5.44
⑩	Эрдэс нунтагийн хувь	%		11+⑤		1.55

Д/Д	Шигшүүрийн Хэмжээ (мм)	Үлдэгдэл Жин (г)	Үлдэгдэл хувь (%)	Өнгөрсөн хувь (%)	Техникийн шаардлага	орц
1	25	0.0	0.0	100.0	100.0	
2	19.0	0.0	0.0	100.0	95-100	16.6
3	12.5	155.0	16.6	83.4	70-90	
4	9.5	72.6	7.8	75.7		28.3
5	4.75	191.9	20.5	55.1	35-55	
6	2.36	196.4	21.0	34.1	20-35	21.0
7	1.18	113.8	12.2	22.0		
8	0.600	82.3	8.8	13.2	11-23	
9	0.425	30.9	3.3	9.9		32.6
10	0.300	31.8	3.4	6.5	5-16	
11	0.150	28.2	3.0	3.5	4-12	
12	0.075	17.9	1.9	1.55	2-7	1.6
13	0.000	14.5	1.55	0.0		

935.3



Шинжилгээний дүнгээс үзэхэд хуучин хучилтын битумын хувь, ширхэглэлийн бүрэлдэхүүн болон бат бэхийн үзүүлэлтүүд техникийн шаардлагын зохих үзүүлэлтүүдэд хүрч байгаа тул энэхүү хэсэгт шууд 5см өнгөлөхөөр тусгасан.

Хуучин карьер, шороон ордын шинжилгээ

“Өвөрхангай АЗЗА” ТӨҮГ-н ашиглаж буй Царцаа хайрханы шороон орд нь Тарагт сумын нутагт хамрагдах бөгөөд Км399+000 баруун 400м-т Соёмботой уулын баруун доор байрладаг. Энэхүү шороон ордоос далан суурийн иж бүрэн шинжилгээ болон ЦБС орцыг итгэмжлэгдсэн лабораторит гаргуулав. Техникийн шаардлагын дагуу 3.75МПа-р график байгуулахад сонгогдсон хамгийн багадаа цементийн орц 4.4% байхаар байна.



**ХЯНАЛТ СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ  
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**



Лаборатори № TL 89

**ДАЛАН СУУРИЙН МАТЕРИАЛЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**

**Дугаар: он/№** 18/190  
**Гүйцэтгэгч:** "RCSC" ХХК  
**Материалын зориулалт:** Далангийн дүүргэлтэнд  
**Объектын нэр:** Өвөрхангай аймаг А0301 371-441 км 60 км авто замын өргөтгөл шинэчлэл  
**Дээж авсан байршил :** Царцаа хайрхан карьер  
**Дээж авсан хүний нэр, албан тушаал :** Инженер Наранбаатар  
**Шинжилгээнд ирүүлсэн дээжний** **Хүлээн авсан огноо** **Шинжилсэн огноо**  
 50 кг 2018.08.17 2018.09.03

Шинжилгээний аргын стандарт	Шинжилсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	Техникийн шаардлага	Үр дүн
MNS ASTM D2217:2014	53мм	%		100
MNS ASTM D2217:2014	37.5 мм	%		100.00
MNS ASTM D2217:2014	25мм	%		100.00
MNS ASTM D2217:2014	19 мм	%		91.07
MNS ASTM D2217:2014	9.5 мм	%		65.91
MNS ASTM D2217:2014	4.75 мм	%		43.05
MNS ASTM D2217:2014	2.36 мм	%		25.33
MNS ASTM D2217:2014	0.425 мм	%		6.25
MNS ASTM D2217:2014	0.075 мм	%		0.87
MNS ASTM D2217:2014	Хамгийн том ширхэглэл	мм		19
MNS ASTM D2217:2014	Ижил байдлын итгэлцүүр	%	5<	7.60
MNS ASTM D 4318:2006	Уян налархайн хязгаар	%		0.00
MNS ASTM D 4318:2006	Урсалтын хязгаар	%	<25	14.00
MNS ASTM D 4318:2006	Урсалт уян налархайн индекс		0-6	0.00
MNS ASTM D 1883:2002	Хөөлт	%	1>	0.03
MNS ASTM D 1883:2002	Хөрсний ачаа даацыг тодорхойлох	%	>30	32.0
MNS ASTM D 1557:2002	Хуурай үеийн хамгийн их нягт	г/см	1.70<	2.185
MNS ASTM D 1557:2002	Тохиромжтой чийгийн агуулалт	%		5.6

Лабораторийн эрхлэгч : ..... / Ч.Баттулга /  
 Туршилт хийсэн инженер : ..... / Д.Батхишиг /

Энэхүү шинжилгээний үр дүн нь зөвхөн лабораторид ирсэн тухайн дээжинд хамаарна.



**ХЯНАЛТ СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ  
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**



**ЦЕМЕНТЭЭР БЭХЖҮҮЛСЭН СУУРЬ**


Дугаар: он/№ : 18/316  
 Дээж ирүүлсэн газрын нэр: "RCSC" ХХК  
 Материалын зориулалт: Цементээр бэхжүүлсэн суурь  
 Объектын нэр: Өвөрхангай Арвайхээр  
 Орд газар: Царцаа хайрхан карьер  
 Дээж авсан хүний нэр албан тушаал: инженер Наранбаатар  
 Шинжилгээнд ирүүлсэн дээжний тоо Хүлээн авсан огноо

Цементийн орц	Хугацаа	Шахалтын бат бэх, МПа	Тооцоогоор	
			кг/см <sup>2</sup>	
2%	7 хоног	1.6	2.36	
		1.8	2.66	
		1.80	2.66	
<b>дундаж утга</b>		<b>1.73</b>	<b>2.56</b>	
4%	7 хоног	2.5	3.69	
		2.4	3.55	
		2.00	2.96	
<b>дундаж утга</b>		<b>2.30</b>	<b>3.40</b>	
6%	7 хоног	2.9	4.29	
		3.4	5.02	
		3.10	4.58	
<b>дундаж утга</b>		<b>3.13</b>	<b>4.63</b>	
8%	7 хоног	4.1	6.06	
		3.75	5.54	
		3.90	5.76	
<b>дундаж утга</b>		<b>3.92</b>	<b>5.79</b>	

Хянаж баталгаажуулсан лаб эрхлэгч : ..... / Ч.Баттулга /

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер: ..... / Д.Батхишиг /

Лабораторийн шинжилгээний үр дүн нь зөвхөн лабораторид ирсэн дээжинд хамаарна.



Бурхийн карьер нь Арвайхээр хотын баруун талд онгоцны буудлаас 3.8км-т байрлах бөгөөд “Өвөрхангай АЗЗА” ТӨҮГ болон орон нутаг дотоодын хэрэгцээнд ашиглаж буй Тарагт сумын нутагт хамаарах карьер юм. Итгэмжлэгдсэн лабораторит ЦБС орцыг тогтоон, далан суурийн иж бүрэн шинжилгээ хийлгэв. Техникийн шаардлагын дагуу 3.75МПа-р график байгуулахад сонгогдсон хамгийн багадаа цементийн орц 5.2% байхаар байна.



**ХЯНАЛТ СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ  
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**



Лаборатори № TL 89

**ДАЛАН СУУРИЙН МАТЕРИАЛЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**

Дугаар: он/№ 18/188  
 Гүйцэтгэгч: "RCSC" ХХК  
 Материалын зориулалт: Даланд  
 Объектын нэр: Өвөрхангай аймаг А 0301 371-441 км 60км авто замын шинчлэл  
 Дээж авсан байршил : Бурхи карьер  
 Дээж авсан хүний нэр, албан тушаал : Инженер Наранбаатар  
 Шинжилгээнд ирүүлсэн дээжний Хүлээн авсан огноо Шинжилсэн огноо  
 50 кг 2018.08.17 2018.09.06

Шинжилгээний аргын стандарт	Шинжилсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	Техникийн шаардлага	Үр дүн
MNS ASTM D2217:2014	53мм	%		100
MNS ASTM D2217:2014	37.5 мм	%		100.00
MNS ASTM D2217:2014	25мм	%		83.74
MNS ASTM D2217:2014	19 мм	%		74.37
MNS ASTM D2217:2014	9.5 мм	%		46.06
MNS ASTM D2217:2014	4.75 мм	%		28.58
MNS ASTM D2217:2014	2.36 мм	%		16.78
MNS ASTM D2217:2014	0.425 мм	%		5.91
MNS ASTM D2217:2014	0.075 мм	%		2.85
MNS ASTM D2217:2014	Хамгийн том ширхэглэл	мм		31.5
MNS ASTM D2217:2014	Ижил байдлын итгэлцүүр	%	5<	5.21
MNS ASTM D 4318:2006	Уян налархайн хязгаар	%		9.76
MNS ASTM D 4318:2006	Урсалтын хязгаар	%	<25	13.00
MNS ASTM D 4318:2006	Урсалт уян налархайн индекс		0-6	3.24
MNS ASTM D 1883:2002	хөөлт	%	1>	0.03
MNS ASTM D 1883:2002	Хөрсний ачаа даацыг тодорхойлох	%	>30	35.0
MNS ASTM D 1557:2002	Хуурай үеийн хамгийн их нягт	г/см	1.70<	2.195
MNS ASTM D 1557:2002	Тохиромжтой чийгийн агуулгалт	%		6.0
	Байгалийн чийг			

Лабораторийн эрхлэгч : ..... / Ч.Баттулга /  
 Туршилт хийсэн инженер : ..... / А.Долгор /

Энэхүү шинжилгээний үр дүн нь зөвхөн лабораторид ирсэн тухайн дээжинд хамаарна.

Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн хатуу хучилттай автозамын К353+600-К411+160км хэсгийн засварын ажлын тайлбар бичиг

## 2.6. ХӨДӨЛГӨӨНИЙ ЭРЧМИЙН СУДАЛГАА

Авто замын нэр:

Улаанбаатар-Өвөрхангай  
А0301

Гүйцэтгэгч байгууллага:

Ар Ди Эй Си ХХК

Авто замын дугаар:

А0301

Тооллого явуулсан он сар өдөр:

2018.08.03-2018.08.11

Тооллого явуулсан газрын нэр:

Онгийн голын гүүр, ТХЦэг

Гүйцэтгэсэн хүний нэр, албан тушаал:

Золжаргал, Захирал

Замын чиглэлийн нэр:

Улаанбаатар-Өвөрхангай

Цаг агаарын байдал:

Бороотой

Он сар өдөр	Хаанаас хаа хүртэл	Суудлын автомашин	Бага даацын ачааны тэрэг	Дунд даацын ачааны машин		Хүнд даацын ачааны машин		Даац хэтэрсэн автомашин	Автобус			Трактор	Мотоцикль	Нийт
				Дан	Чиргүүлтэй	Дан	Чиргүүлтэй		Бичил	Дунд	Том			
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
2018.08.03	УБ-ӨВ	692	65	17	2	14	8	19	57	2	15	0	35	907
	ӨВ-УБ	693	54	16	4	16	5	11	66	3	28	0	60	945
2018.08.04	УБ-ӨВ	572	47	25	1	25	28	26	43	3	22	0	37	803
	ӨВ-УБ	658	46	23	9	24	17	21	31	5	23	0	40	876
2018.08.05	УБ-ӨВ	841	61	32	3	15	16	11	28	3	24	0	67	1090
	ӨВ-УБ	841	48	20	2	17	27	27	25	6	25	1	50	1062
2018.08.06	УБ-ӨВ	765	83	23	0	18	6	15	37	3	32	0	60	1027
	ӨВ-УБ	770	61	23	4	22	11	28	53	1	27	0	90	1062
2018.08.07	УБ-ӨВ	508	54	21	3	31	16	16	38	2	25	0	14	712
	ӨВ-УБ	611	62	18	1	33	9	24	37	3	30	1	13	818
2018.08.08	УБ-ӨВ	834	67	26	1	19	4	19	68	1	28	0	41	1108
	ӨВ-УБ	786	58	36	0	18	6	29	42	5	16	0	21	988
2018.08.09	УБ-ӨВ	767	64	27	2	24	4	43	60	7	21	0	46	1022
	ӨВ-УБ	723	67	26	3	23	7	23	56	5	17	1	22	973
2018.08.10	УБ-ӨВ	805	59	28	2	18	2	28	60	1	29	0	47	1051
	ӨВ-УБ	837	64	23	2	30	8	19	66	1	22	0	23	1077
	Нийт дүн	11703	960	384	39	347	174	359	767	51	384	3	666	15521
	Хоногийн дундаж хөдөлгөөний эрчим	1463	120	48	5	43	22	45	96	6	48	0	83	1980

## 2.7. ХООЛОЙН СУДАЛГАА

Улаанбаатар - Арвайхээр <А0301> чиглэлийн их засвар хийгдэх замд хиймэл байгууламжуудад үзлэг хийж фото зураг болон бусад баримт материалаар баталгаажуулсан. Хоолой бүр дээр карт хийж засварын ажлыг тодорхойлж засварын зураг төсөл боловсруулсан болно. Хиймэл байгууламжуудын хувьд олон жил засвар хийгдээгүйн улмаас ихээхэн эвдэрсэн байна. Ихэнх хоолой дээр өнгөлгөөний бетон ховхорч унасан, хоолойн цагиргууд хэв гажилтанд орж зөрсөн, шороонд дарагдсан, толгой далавч эвдэрсэн, орох гарах хэсгийн чулуун бэхэлгээ угаагдаж урссан зэрэг эвдэрлүүд үүссэн байгаа тул засварлахаар төлөвлөсөн, мөн ус ихээхэн тогтдог 8 цэгийн хоолой шинээр хийх, нийт 59 хоолойны 28 хоолойг шинэчлэхээр тусгасан. Шинэчлэх хоолойнд ихэвчлэн ус өнгөрүүлэх хэмжээг ихэсгэх зорилгоор одоо байгаа хоолойн хэмжээг томруулах, уртасгах ажлууд төлөвлөгдсөн.

### Хүснэгт-4.Хоолойн эвдрэлийн судалгаа

№	Байрлал	Диаметр/м/	Хоолойн урт /м/	Хоолойны төрөл	Шинэ цэгт хоолой барих	Засварын ажлын төрөл					
						Хоолой шинэчилж барих	Толгой, далавч шинээр хийх	Тосгуур шинээр хийх	Чулуун бэхэлгээ шинээр хийх	Хажуу налуугийн чулуун бэхэлгээ хийх	Хоолойн дээрх дохионы шон нэмж байршуулах
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	КМ355+747	1.0м	16.1	Дугуй			√	√	√		1
2	КМ356+012	1.0м	16	Дугуй			√	√	√	√	
3	КМ356+683	1.0м	16	Дугуй			√	√	√	√	
4	КМ357+035	1.0x0.75 м			√						
5	КМ357+855	1.0м	16	Дугуй			√	√	√	√	
6	КМ359+426	1.0м	16	Дугуй			√	√	√	√	
7	КМ360+455	1.5м	15.2	Дугуй			√	√	√	√	
8	КМ360+954	1.0м	14.4	Дугуй		√		√	√	√	
9	КМ361+634	1.0м	14.8	Дугуй		√					
10	КМ361+715	1.0x0.75 м			√						
11	КМ363+095	1.0м*3	14.4	Дугуй		√					
12	КМ364+889	1.0м	16.1	Дугуй		√		√	√	√	
13	КМ365+674	1.0м	15.5	Дугуй			√	√	√	√	2
14	КМ366+868	1.5м*2	16.5	Дугуй		√					
15	КМ368+108	1.5м	17.2	Дугуй			√	√	√	√	
16	КМ368+534	1.5м	17	Дугуй		√					
17	КМ369+282	1.0x1.0 x2	14.2	Дугуй		√		√	√	√	3
18	КМ369+800	1.5м	15.9	Дугуй			√	√	√	√	
19	КМ370+017	1.0x0.75 м			√						

Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн хатуу хучилттай автозамын К353+600-К411+160км хэсгийн засварын ажлын тайлбар бичиг

20	КМ370+550	1.5м	16	Дугуй			✓	✓	✓	✓		
21	КМ370+972	1.5м	16	Дугуй			✓	✓	✓	✓		
22	КМ371+760	1.5м	16	Дугуй			✓	✓	✓	✓		
23	КМ372+518	1.5м	15.8	Дугуй		✓		✓	✓	✓		
24	КМ373+167	1.5м	14	Дугуй			✓	✓	✓	✓		
25	КМ374+060	1.5м	14.5	Дугуй			✓	✓	✓	✓		
26	КМ374+335	1.5м*1.5м	17	Дөрвөлжин					✓	✓	1	
27	КМ374+703	1.5м*1.5м	16.7	Дөрвөлжин			✓		✓	✓		
28	КМ374+970	1.0м	22	Дугуй					✓	✓		
29	КМ376+210	2.0*2.5*2	16	Дөрвөлжин					✓	✓		
30	КМ376+725	1.5м*1.5м	15	Дөрвөлжин			✓		✓	✓		
31	КМ377+101	1.5м	15.5	Дугуй			✓	✓	✓	✓		
32	КМ377+680	1.0м	17	Дугуй		✓						
33	КМ377+960	1.0м	17	Дугуй		✓						
34	КМ378+577	1.5м	14.6	Дугуй		✓						
35	КМ379+640	2.0x1.5x2	18.2	Дөрвөлжин		✓						
36	КМ380+73	1.0м	16.9	Дугуй		✓						
37	КМ380+920	1.0x0.75 м				✓						
38	КМ381+445	1.5м	13.7	Дугуй		✓						
39	КМ381+679	1.0м	18.4	Дугуй		✓						
40	КМ382+021	1.0x0.75 м				✓						
41	КМ382+575	1.5м*2	16.5	Дугуй		✓						
42	КМ383+580	1.0м	14.8	Дугуй		✓						
43	КМ384+235	2.0x1.5x2	14.5	Дөрвөлжин		✓						
44	КМ384+863	1.5м*2	15.7	Дугуй		✓						
45	КМ385+552	1.0м	15.3	Дугуй		✓						
46	КМ386+497	1.5м	15	Дугуй			✓	✓	✓	✓		
47	КМ387+400	1.5м	17.7	Дугуй			✓	✓	✓	✓		
48	КМ388+28	1.5м*3	18.7	Дугуй		✓						
49	КМ388+475	1	11.1	Дугуй			✓	✓	✓	✓	1	
50	КМ390+078	1.0x0.75 м				✓						
51	КМ391+040	2.0x1.5x2	15.5	Дөрвөлжин		✓		✓	✓	✓	2	
52	КМ391+580	1.5м*3	16.3	Дугуй		✓					1	
53	КМ393+016	1.0м	16.7	Дугуй			✓	✓	✓	✓		
54	КМ393+971	1.0м	16.7	Дугуй			✓	✓	✓	✓		
55	КМ394+964	1.0м	19.3	Дугуй			✓	✓	✓	✓		
56	КМ397+857	1.0м	14.6	Дугуй		✓						
57	КМ398+686	2.0x1.5x2	17.7	Дөрвөлжин		✓						
58	КМ398+995	2.0x1.5x2	17.3	Дөрвөлжин		✓						
59	КМ399+789	2.0x1.5x2	14.5	Дөрвөлжин		✓						
60	КМ400+394	1.0м	14.7	Дугуй			✓	✓	✓	✓		
61	КМ402+606	5.4м*1.25м	15.5	Дөрвөлжин				✓	✓			
62	КМ403+170	1.0x0.75 м				✓						
63	КМ403+632	1.0x0.75 м				✓						
64	КМ407+284	1.0м	12.2	Дугуй			✓	✓	✓	✓		
65	КМ407+880	1.0x1.0 x2	14.2	Дугуй		✓		✓	✓	✓		
66	КМ409+100	1.0м	12	Дугуй			✓	✓	✓	✓		
67	КМ410+414	1.6м*0.95м	14.2	Дөрвөлжин							1	
НИЙТ						8	28	26				12

## **2.8. ЗАМЫН ТОНОГЛОЛЫН СУДАЛГАА**

### ***Замын хучилтын тэмдэглэгээ***

Замын хучилтын хэвтээ тэмдэглэгээний гэрэл ойлголт, зузааныг MNS 4759:2003 Замын тэмдэглэлийн техникийн ерөнхий шаардлага стандартын дагуу шалгалаа. Замын хэвтээ тэмдэглэгээ /голын цагаан зураас болон бусад/ бүдгэрсэн, арилж үгүй болсон байна. Иймд тэнхлэгийн цагаан зураасыг нийт замын уртад тодруулж шинэчлэх шаардлагатай байна. Хэвтээ тэмдэглэгээний гэрэл ойлголтын түвшин MNS 4759:2003 стандартын 5.7-р зүйлд заасан “Замын тэмдэглэгээний цагаан зураасны өргөний 2/3-ыг гэрэл ойлгогч будаг буюу хальсаар голлуулан бүрсэн байна” гэсэн шаардлагыг бүрэн хангахгүй байна.

### ***Замын тоноглол***

Замын тоноглол, тэмдэгжүүлэлтийг авто зам, замын байгууламжийн арчлалт засварын зохион байгуулалтын дүрэм /ЗЗБНБД 41-011-2016/-д зааснаар бэлэн байдлын түвшин талаас нь үнэлсэн болно. Энэ чиглэлийн замд тэмдэг /км-ийн шон, анхааруулах болон заах тэмдэгүүд, түмбэ, хашлага хаалт зэрэг багтана/ байгаа боловч хэмжээ янз бүр, өнгө үзэмж муу, гэрлийн ойлгох чадвар муудсан зэрэг нийтлэг эвдэрлүүд гарсан байна. Түмбэ болон километрийн шонгуудыг дахин сэргээх. Зарим хугарсан, алга болсон түмбэ, километрийн шонг байрлуулах шаардлагатай байна. Одоогийн байдлаар дээрх замд байршуулсан байгаа 107 тэмдэг байгаагаас 52 нь км-ийн заалтын тэмдэг, 19 нь түр тэмдэг, стандартын шаардлага хангаагүй 8 тэмдэг, ашиглах боломжтой 28 тэмдэг байна.

### ***Замын хашилт***

Улаанбаатар – Арвайхээр чиглэлийн их засвар хийгдэх 57,56км авто замд туузан хашлага нь авто осол гадны нөлөөний улмаас муруйсан гажсан байдлаас бусад эвдрэл гэмтэл гараагүй байсан болно.

### **БҮЛЭГ-3. СУДАЛГААНЫ РАЙОНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

#### **3.1. ГАЗАР ЗҮЙН БАЙРШИЛ**

Аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээ 63.5 мянган км.кв, хойноос урагшаа 385 км, зүүнээс баруун хил хүртэл 310 км, улсын нийслэл Улаанбаатар хотоос 430 км зайд оршдог. Нутгийн хойд хэсэгт Хангайн нурууны, өмнө хэсгээр нь Алтай нурууны салбар уулстай, аймгийн нийт нутгийн 23.0 хувь нь хангайн, 28.2 хувь нь тал хээрийн, 48.8 хувь нь говийн бүсэд оршдог. Өвөрхангай аймаг нь Монгол улсын төв хэсэгт Архангай, Булган, Баянхонгор, Төв, Дундговь, Өмнөговь аймгуудтай хиллэдэг. Газар зүйн байрлалаар далайн түвшнээс 1813 метрт өргөгдсөн, 102 градус 47 минутын уртраг 46 градус 16 минутын өргөрөгт, хойноос урагшаа 385 км, зүүнээс баруун хил хүртэл 310 км үргэлжилнэ.

#### **3.2. УУР АМЬСГАЛ**

Судалгааны район нь Монгол орны бусад нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай бөгөөд ерөнхийдөө өвөл нь удаан (хүйтэвтэр, байнга цас их унадаг, эрс хүйтрэх, хүчтэй салхилах), зун нь богино (аагим халуун, их бороо орох, зарим жил ган болох), хавар, намар уулсын хөндий дагасан салхи их тохиолдох чийглэг хахир хүйтэн байх уур амьсгалын бичил мужид оршино.

Уур амьсгалын үндсэн үзүүлэлтийг Өвөрхангай аймгийн Арвайхээр харуулын олон жилийн ажиглалтын материалыг болон “Барилгад хэрэглэх уур амьсгалын ба геофизикийн үзүүлэлтүүд” /БНБД 2.01.01-93/, “Барилгад хэрэглэх уур амьсгалын ба геофизикийн үзүүлэлтүүд” (Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл) /БНБД 2.01.01-2004/-ийг ашиглан агаарын температур, хөрсний температур, агаарын чийгшил, салхины горим гэсэн үзүүлэлтээр өгч хүснэгтээр харуулав.

##### **3.2.1. Агаарын температур**

Судалгааны бүс нутагт олон жилийн агаарын температур  $+1.4^{\circ}\text{C}$   $-1.6^{\circ}\text{C}$  байгаа нь сэрүүн бүсэд багтахыг харуулна. Агаарын температур хавар 3-р сарын сүүлчийн арав хоногт  $0^{\circ}\text{C}$ -ийг давж дулаарч, хамгийн дулаан 7-р сард  $+15,4$ -оос  $+20,1^{\circ}\text{C}$  дундажтай байх ба үнэмлэхүй их нь  $+33,2^{\circ}\text{C}$  байна. Намар 10-р сарын дунд арав хоногт  $0^{\circ}\text{C}$ -ийг давж хүйтэрч, хамгийн хүйтэн 1-р сард  $-19.8^{\circ}\text{C}$ -ээс  $-23.5^{\circ}\text{C}$  дундажтай байх ба үнэмлэхүй бага нь  $-42.6^{\circ}\text{C}$  байна.

Агаарт цочир хүйтрэлт жил болгон ажиглагдахгүй боловч олон жилийн дундажаар цочир хүйтрэлт ажиглагдах анхны хугацаа нь намар 9-р сарын дунд арав

хоногт, эцсийн хугацаа нь хавар 5-р сарын эхээр ажиглагдаж цочир хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 93-120 орчим хоног байна.

### **3.2.2. Хөрсний температур**

Бүс нутгаар хөрсний гадаргын температурын олон жилийн дундаж температур  $+3.8^{\circ}\text{C}$  байх ба агаарын температурын жилийн явцтай нэгэн адил 1-р сард хамгийн хүйтэн (үнэмлэхүй бага температур  $-47.6^{\circ}\text{C}$ ), 7 дугаар сард хамгийн дулаан (үнэмлэхүй их температур  $+64.5^{\circ}\text{C}$ ) байна.

Хөрсний гүнд улирлын хөлдөлтөөр 3.2м хүрч хөлдөх ба хөрсний гүнд ховор алаг цоог тархацтай цэвдэгтэй бүсэд оршино.

### **3.2.3. Чийгшил ба тунадас**

Судалгааны районд газар зүйн байрлал болон хур тунадасны хэмжээ зэргээс хамаарч хагас чийглэг, чийглэгдүү уур амьсгалтай бүсэд багтана. Жилийн дулаан улирлын дундаж харьцангуй чийгшил 50-70% байна. Хүйтний улиралд агаарын харьцангуй чийгшил 80-85%, харин дулааны улиралд 60-70% байх ба жилийн явц нь өвөл, зун их утгаа авч хавар, намар хамгийн багасч 40-55% болдог байна.

Уг бүс нутгийн хур тунадасны горим нь агаар мандлын орчил урсгал, орон нутгийн хотгор, гүдгэрийн байдал, цаг улирал, дэвсгэр гадаргаас уурших ууршил зэргээс хамаарна. Олон жилийн дундаж байдлаар 77.0-325.0мм тунадас унах ба нийт хур тунадасны 80-90 орчим хувь нь зөвхөн дулааны улиралд буюу 5-9 дүгээр саруудад ордог байна. Анхны цас өндөр ууландаа эрт буюу 8-р сарын сүүлчээр, эцсийн цас 6-р сарын эхний 10 хоногт ордог байна. Өвөл 5-10 см зузаан цасан бүрхүүл 110-150 хоног тогтож 4-р сарын дунд арав хоногт сүүлчийн цас ажиглагдах ба 3 дугаар сарын дундаас хайлж эхэлдэг. Манай орны газар нутгийн хотгор, гүдгэрийн ялгаанаас шалтгаалж цасны зузаан нь нутаг бүхэнд харилцан адилгүй байна. Цасан бүрхүүлийн зузааны горимыг цасны 10 хоногийн дундаж зузаан, цасны хамгийн их зузааны дундаж зэрэг үзүүлэлтээр илэрхийлдэг. Цасны хээрийн хэмжилтээр гаргасан 10 хоногийн дунджаас үзвэл уулархаг хэсэгт (уулсын хоорондох хөндий) 15 см ба түүнээс дээш, хээрийн бүсэд 5 см хүртэл, говьд 1-2 см-ээс төдийлөн хэтэрдэггүй байна. Цасны нягт  $0.17\text{г}/\text{см}^3$  байдаг

### **3.2.4. Салхи**

Тус районд баруун ба баруун хойт зүгийн салхи зонхилох ба харин хүйтний улиралд зүүн ба зүүн өмнөд зүгийн салхи зонхилно. Салхины хурд олон жилийн дунджаар 1.6-3.8 м/с байх ба 100 жилд тохиолдож болох салхины хурд 30.0 м/с байна.


### 3.3. АВТО ЗАМЫН УУР АМЬСГАЛЫН НӨХЦӨЛ

Төслийн автозамын судалгааны талбай нь Монгол орны зам-уур амьсгалын бүсчлэлээр хээрийн бүсийн IIВ-уулын завсар хоорондын дэд бүсэд хамаарна.

#### Хүснэгт-5. Авто замын дагуух бүсүүдийн уур амьсгалын, геотехникийн үзүүлэлт

Бүсийн дугаар, нэр	Дэд бүсийн индекс	Бүсийн товч тодорхойлолт	Уур амьсгалын болон хөрсний нөхцөл.
II Авто замын амьсгалын хээрийн бүс	IIВ. Уулын завсар хоорондын тал хээрийн дэд бүс	-Авто замын уур амьсгалын хуурай-хүйтэн сэрүүвтэр хахир, хуурайдуу, сэрүүвтэр хүйтэн бэсрэг уулт хээр, хээр талын хахирлаг дэд бүс.	-Тал хээрийн дэд бүс нь улирлын хөлдөлттэй овойлт болон суулт үүсгэнэ. Цас нимгэн, хахир өвөлтэй. -Газар хөдлөл 6-7 балл.

Төлөвлөгдөж буй трассын дагуух уур амьсгалын нөхцөлийг илүү тодорхой судлах, уур амьсгалын өөрчлөлтийн байдлыг тусгахын тулд Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын цаг уурын станцуудын сүүлийн арван жилийн буюу 2008-2018 оны цаг уурын мэдээг анхдагч эх үүсвэрээс авч ашигласан.



Зураг-15. Монгол орны авто замын уур амьсгалын бүсчлэл

### Хүснэгт-6. Улирлын үргэлжлэх хугацаа

Дэд бүс	Өвөл			Хавар		Зун		Намар
	Эхлэх	Дуусах	Үргэлжлэх хоног	Дуусах	Үргэлжлэх хоног	Дуусах	Үргэлжлэх хоног	Үргэлжлэх хоног
IIВ	1-9ХI 5.ХI	15-24.III 19.III	126-143 134	8-12.Y 9.Y	45-52 48	8-19.IX 13.IX	112-156 129	44-54 49

Тайлбар:

\* өвлийн дуусах хугацаа хаврын эхлэл, хаврынх зуны эхлэл, зуных намрын эхлэл, өвлийн эхлэл намрын дуусах хугацаа болно.

### Хүснэгт-7. Хөрс, агаарын температурын (°C) үзүүлэлт

Дэд бүс	Хөрсний гадаргын температур, °C				Агаар орчны дундаж температур		
	Олон жилийн дундаж	Хамгийн халуун	Хамгийн хүйтэн	0° нэвчих гүн, см*	Олон жилийн дундаж	Хамгийн хүйтэн сарын	Хамгийн дулаан сарын
IIВ	+0...+3	60-65	-41...-45	250-350	-2...+2	-20...-25	15...20

Тайлбар: \* -00C нэвчих гүн ул хөрсний төрлөөс хамаарах тул дээд, доод хязгаарыг авав.

### Хүснэгт-8. Хөрсний хөлдөлт-гэсэлтийн уур амьсгалын хугацаа

Дэд бүс	Хөлдөлт			Гэсэлт		
	Эхлэх	Дуусах	Хоног	Эхлэх	Дуусах	Хоног
IIВ	20-30.X 25.X	15.III-30.IY 5.IY	120-195 160	15.III-10.IY 25.III	15.IY-31.Y 23.IY	20-50 35

### Хүснэгт-9. Авто замын барилгын үйлдвэрлэлийн ажил явуулахад тохиромжтой болон тохиромжгүй улирлын үеүүд

Дэд бүс	Дулааны улирал *			Хүйтний улирал
	Эхлэх	Дуусах	Хоног	Хоног
IIВ	10.IY	19.X	192	173

Тайлбар: - Авто замын барилгын үйлдвэрлэлийн хүйтний улирлын эх нь дулааны улирлын төгсгөл, хүйтэн улирлын төгсгөл нь дулааны улирлын эх болдог

**Хүснэгт-10. Авто замын уур амьсгалын жилийн 4 улирлын салхины хурд, агаарын даралт, харьцангуй чийгшил**

Дэд бүс	Салхины хурд, м/с				Даралт, мм Hg баганын өндрөөр	Харьцангуй чийгшил, %
	Өвөл	Хавар	Зун	Намар		
IIВ	1.6-4	3-7	2-4	2.5-5.5	600-650	50-60

**Хүснэгт -11. Хээр гадаа ажиллах авто замын ажилчдын хөдөлмөрийн био уур амьсгалын нөхцөл**

Дэд бүс	Хүчилтөрөгч-чийн нягт, г/см3	Хувцас хунарын дулаан чанар, КЛО (хүндэвтэр ажлыг нөхцлөөр тооцов)			Уур амьсгал хүний биед, хоног		
		өвлийн	Хавар, намрын	Зуны	Таатай	Цочроох	Хурц
IIВ	250-260	4.6-5.5	2.8-3.0	1.5-1.7	175-190	110-120	80-90

**Хүснэгт-12. Авто замын үйлдвэрлэл, замчдын хөдөлмөртүүр амьсгалын нөлөөллийг үнэлэх итгэлцүүрүүд**

Дэд бүс	Нөлөө үйлчлэлийн итгэлцүүр				
	Хүйтний	Хахирын	Халууны	Хур тунадасны	Чийгшлийн
IIВ	1.00	1.00	1.00	1.00	1.00

**Хүснэгт-13. Авто замын уур амьсгалын бүсүүдэд халуун асфальт бетон хольц бэлтгэж дэвсэхэд тохиромжтой хугацаа**

Дэд бүс	Асфальт болон замын хучилт		
	Эхлэх	Дуусгах	Хоног
IIВ	18.IY-16.Y (2.Y)	15.III-19.IX (1.IX)	91-154 (122)

**Хүснэгт-14. Авто замын уур амьсгалын бүсүүдэд хүйтэн, бүлээн асфальт бетон хучилт хийхэд тохиромжтой хугацаа**

Дэд бүс	Асфальт болон замын хучилт		
	Эхлэх	Дуусгах	Хоног
IIВ	3-30.III (16.III)	30.X-4.XII (15.XI)	220-278 (250)

#### БҮЛЭГ-4. БАЙРЗҮЙН СУДАЛГАА

Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн А0301 чиглэлийн автозамын засвар, шинэчлэлтийн ажлын нарийвчилсан зураг төсөлд зориулсан одоо байгаа асфальт бетон замын хуучин км шонгийн км371-км431-ын хоорондох 60 км хатуу хучилттай автозамын хэмжилтийн ажлыг гүйцэтгэсэн. Уг хэсгийн замын трасс нь засаг захиргааны хувьд Өвөрхангай аймгийн Хужирт, Зүүнбаян улаан, Өлзийт сумдууд болон аймгийн төв Арвайхээр хотыг дайран өнгөрч байна.

